



## “ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03-р сарын 02-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г

Г

Хувьцаа эзэмшигчдийн хурал  
хуралдуулах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналыг  
үндэслэн ТОГТООХ НЬ :

Нэг. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 15-ны өдрийн 15.00 цагт компанийн байранд хуралдуулсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2026 оны 03-р сарын 06-ны дотор багтаан СЗХ-ны 2018 оны 377-р дугаар тогтоолын 3-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Б.Мөнхбатыг томилсугай.

Дөрөв. Хурал зохион байгуулах болон хурлын тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй ажиллуулсугай.

Үүнд: О.Шинэхүү  
Ж.Олонбаяр  
Ч.Саранзаяа

Тав. Хурлаар дараахь асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
5. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.МӨНХБАТ